



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [BoldbaatarKh@audit.gov.mn](mailto:BoldbaatarKh@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: [b.dagvaa1000@gmail.com](mailto:b.dagvaa1000@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 122

гаруй \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДӨРВӨЛЖИН СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ц. БЯМБАСҮРЭН-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хүүхдийн цэцэрлэгт иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, төгсөгчдөөс 13,111.4 мянган төгрөгийн, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 14,185.6 мянган хандив тусламж өгсөнийг данс бүртгэлд тусгасан байна. Мөн сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 20,000.0 мянган төгрөгийн тоглоомын талбайн тохижилт, татварын давсан орлогоос сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 2,500.0 мянган төгрөгийн тоглоом, 2,500.0 мянган төгрөгийн гадна хаяг, гэрэлтүүлэг хийсэн байна. "Ган доной" ХХК-д төлөх өмнөх оны 9,913.6 мянган төгрөгийн халаалтын өглөгийг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлжээ.

### Аудитын гол асуудал

Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 78 арга хэмжээ төлөвлөж, 100 хувь хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,062,921.38	116,381,581.38
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	77,105,127.79	43,597,037.79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	77,105,127.79	43,597,037.79
3121	Төгрөг	77,105,127.79	43,597,037.79
31211	Төрийн сангийн харилцах	24,716,477.79	43,597,037.79
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	52,388,650.00	-
33	АВЛАГА	2,446,999.74	2,446,999.74
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	2,446,999.74	2,446,999.74
35	БАРАА МАТЕРИАЛ	54,510,793.85	70,337,543.85
351	Түүхий эд материал	13,320,476.00	17,447,526.00
35110	Тусгай зориулалттай материал	13,150,476.00	17,277,526.00
35130	Эм боох материал	170,000.00	170,000.00
354	Хангамжийн материал	41,190,317.85	52,890,017.85
35410	Бичиг хэргийн материал	499,800.00	553,800.00
35420	Аж ахуйн материал	16,603,811.85	27,855,911.85
35430	Сэлбэг хэрэгсэл	270,000.00	494,000.00
35440	Түлш шатах тослох материал	-	157,000.00
35460	Хүнсний материал	100.00	12,700.00
35470	Бусад хангамжийн материал	23,816,606.00	23,816,606.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,382,981,797.33	1,379,516,178.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,382,981,797.33	1,379,516,178.57
392	Биет хөрөнгө	1,374,083,797.33	1,370,948,178.57
39201	Барилга, байгууламж	1,591,800,000.00	1,591,800,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(255,351,249.86)	(281,881,249.82)
39205	Машин, тоног төхөөрөмж	47,636,289.00	65,386,489.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,306,589.17)	(32,531,950.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,059,537.69	21,059,537.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,177,516.23)	(11,307,974.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,999,999.98)
39217	Номын фонд	423,325.90	423,325.90

393	Биет бус хөрөнгө	8,898,000.00	8,568,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,748,000.00	9,748,000.00
39304	Хасагдуулга	(850,000.00)	(1,180,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,517,044,718.71	1,495,897,759.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,913,589.67	(0.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,913,589.67	(0.00)
413	Өглөг	9,913,589.67	(0.00)
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	(0.00)
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,913,589.67	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,507,131,129.04	1,495,897,759.95
51	Засгийн газрын хувь оролцоо	1,507,131,129.04	1,495,897,759.95
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	29,404,158.69	29,404,158.69
51101	Өмч: -Төрийн өмч	29,404,158.69	29,404,158.69
512	Хуримтлагдсан үр дүн	1,475,092,328.35	1,463,858,959.26
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,092,328.35	1,475,092,328.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,233,369.09)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,634,642.00	2,634,642.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,517,044,718.71	1,495,897,759.95

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	414,027,650.85	532,506,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,875,550.85	50,317,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,875,550.85	50,317,300.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,875,550.85	50,317,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,875,550.85	50,317,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,152,100.00	482,188,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,763,200.00	412,178,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	349,763,200.00	412,178,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,388,900.00	70,010,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,388,900.00	70,010,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	391,396,300.07	543,739,569.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,396,300.07	543,739,569.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,396,050.07	542,392,547.53

2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	232,974,959.00	353,400,068.00
210101	Цалин	177,825,239.00	223,113,335.00
210102	Нэмэгдэл цалин	49,442,581.00	118,482,343.00
210104	Урамшуулал	5,707,139.00	11,804,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,450,263.00	43,901,965.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,100,763.00	29,765,961.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,837,400.00	3,534,001.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,270,200.00	1,767,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	567,400.00	1,767,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,674,500.00	7,068,003.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,264,472.22	56,750,438.77
210301	Гэрэл цахилгааны зардал	3,032,912.22	4,528,828.44
210302	Түлш, халаалтын зардал	45,110,560.00	50,721,910.33
210303	Цэвэр, бохир усны зардал	1,121,000.00	1,499,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,961,880.00	-
210401	Бичиг хэргийн материал	797,480.00	-
210408	Бараа материал актасны зардал	3,164,400.00	-
2105	Нормативт зардал	27,652,575.00	34,568,450.00
210502	Хоол	27,652,575.00	34,243,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	325,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,507,250.00	2,475,450.00
210604	Урсгал засвар	1,507,250.00	2,475,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	672,500.00	713,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	672,500.00	713,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,912,150.85	50,582,675.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,258,300.00	6,955,107.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	895,300.00	2,411,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,758,550.85	41,215,818.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250.00	1,347,021.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	250.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	250.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	-	1,347,021.56
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,347,021.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	22,631,350.78	(11,233,369.09)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	22,631,350.78	(11,233,369.09)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ITEM_NAME	Өмнөх он	Тайлан он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	402,152,100.00	482,188,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,152,100.00	482,188,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,763,200.00	412,178,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	349,763,200.00	412,178,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,388,900.00	70,010,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,388,900.00	70,010,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	356,734,534.61	513,747,290.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,734,534.61	513,747,290.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,734,284.61	512,400,268.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	229,167,359.61	348,916,733.00
210101	Үндсэн цалин	177,825,239.00	226,760,720.00
210102	Нэмэгдэл	45,634,981.61	110,351,573.00
210104	Үр дүнгийн урамшуулал	5,707,139.00	11,804,440.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	35,687,400.00	48,385,300.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,337,900.00	33,893,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,837,400.00	3,622,900.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,270,200.00	1,811,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	567,400.00	1,811,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,674,500.00	7,246,000.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	50,388,900.00	66,664,028.44
210301	Гэрэл цахилгааны зардал	3,565,000.00	4,322,269.97
210302	Түлш, халаалтын зардал	45,113,900.00	60,635,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,710,000.00	1,706,258.47
2105	Нормативт зардал	27,702,675.00	34,581,050.00
210502	Хоол, хүнс	27,702,675.00	34,581,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,999,750.00	1,999,450.00
210604	Урсгал засвар	1,999,750.00	1,999,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	660,100.00	713,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,100.00	713,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,128,100.00	11,140,207.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,147,700.00	7,342,307.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,980,400.00	3,797,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250.00	1,347,021.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,347,021.56
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,347,021.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	250.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	250.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	45,417,565.39	(31,558,390.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,949,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,949,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,949,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,949,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(1,949,700.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	45,417,565.39	(33,508,090.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,687,562.40	77,105,127.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,105,127.79	43,597,037.79

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,437,651,381.72	1,469,690,182.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,437,651,381.72	1,469,690,182.41
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	14,479,595.85	14,479,595.85
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,475,092,328.35	1,507,131,129.04
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,475,092,328.35	1,507,131,129.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,475,092,328.35	1,507,131,129.04
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(11,233,369.09)	(11,233,369.09)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	29,404,158.69	2,634,642.00	1,463,858,959.26	1,495,897,759.95

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,105,127.79	(77,105,127.79)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	541,474,000.00	514,349,968.44	27,124,031.56	94.99
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	541,474,000.00	514,349,968.44	27,124,031.56	94.99
210	Бараа, үйлчилгээний зардал	541,474,000.00	514,349,968.44	27,124,031.56	94.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,512,700.00	348,916,733.00	26,595,967.00	92.92
210101	Үндсэн цалин	254,568,300.00	226,760,720.00	27,807,580.00	89.08
210102	Нэмэгдэл	116,174,200.00	110,351,573.00	5,822,627.00	94.99
210104	Урамшуулал	4,770,200.00	11,804,440.00	(7,034,240.00)	247.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,810,900.00	48,385,300.00	(3,574,400.00)	107.98
210201	Тэтгэврийн даатгал	30,472,000.00	33,893,400.00	(3,421,400.00)	111.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,584,300.00	3,622,900.00	(38,600.00)	101.08
210203	ҮОМШӨ ний даатгал	1,792,400.00	1,811,500.00	(19,100.00)	101.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,792,400.00	1,811,500.00	(19,100.00)	101.07
210205	Эрүүл мэндийн даатгал	7,169,800.00	7,246,000.00	(76,200.00)	101.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,010,500.00	66,664,028.44	1,346,471.56	98.02
210301	Гэрэл цахилгаан	5,665,000.00	4,322,269.97	1,342,730.03	76.30
210302	Түлш, халаалт	60,635,500.00	60,635,500.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,710,000.00	1,706,258.47	3,741.53	99.78
2105	Нормативт зардал	36,134,200.00	34,581,050.00	1,553,150.00	95.70
210502	Хоол, хүнс	36,134,200.00	34,581,050.00	1,553,150.00	95.70
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,999,450.00	550.00	99.97
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,450.00	550.00	99.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,296,900.00	713,500.00	583,400.00	55.02
210806	Мэдээллийн технологийн зардал	1,296,900.00	713,500.00	583,400.00	55.02
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	13,708,800.00	13,089,907.00	618,893.00	95.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,901,200.00	9,282,307.00	618,893.00	93.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,807,600.00	3,807,600.00	-	100.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	541,474,000.00	412,178,400.00	129,295,600.00	76.12
1310	Улсын төсвөөс санхүүжих	471,463,500.00	412,178,400.00	59,285,100.00	87.43

131001	Улсын төсвөөс санхүүжих	471,463,500.00	412,178,400.00	59,285,100.00	87.43
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,105,127.79	(77,105,127.79)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	43,597,037.79	(43,597,037.79)	
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	-	-	-	
61	Байгууллагын тоо	1	1	-	
62	Ажиллагсдын тоо	14.00	14.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	70,010,500.00	70,010,500.00	-	100.00
21	Урсгал зардлын дүн	70,010,500.00	70,010,500.00	-	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	70,010,500.00	70,010,500.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,010,500.00	68,010,500.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	5,665,000.00	5,665,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	60,635,500.00	60,635,500.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,710,000.00	1,710,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,010,500.00	70,010,500.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,010,500.00	70,010,500.00	-	100.00
133001	Урсгал үйл ажиллааны санхүүжилт	70,010,500.00	70,010,500.00	-	100.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

#### Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ төлөвлөснөөс 98 0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

**Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн** үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогтоолуудад өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 21,147.0 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан нь харилцах дансны эцсийн үлдэгдэл буурсантай холбоотой байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	77,105.1	43,597.0	-33,508.1
Авлага	2,447.0	2,447.0	0
Бараа материал	54,510.8	70,337.5	15,826.7
Үндсэн хөрөнгө	1,382,981.8	1,379,516.2	-3,465.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,517,044.7</b>	<b>1,495,897.7</b>	<b>-21,147.0</b>
Өр төлбөрийн дүн	9,913.6	0	-9,913.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,507,131.1	1,495,897.7	-11,233.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,517,044.7</b>	<b>1,495,897.7</b>	<b>-21,147.0</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 33,508.1 мянган төгрөгөөр буурч, бараа материал 15,826.7 мянган төгрөгөөр өссөн бол үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,465.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 54,510.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 44,326.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан бол хандив тусламжаар 14,516.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын болон аж ахуйн материал хүлээн авч, 43,016.8 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр оны эцэст 70,337.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 1,949.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 35,800.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг хандив тусламжаар хүлээн авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 41,215.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 11,233.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

Тайлант оны эцэст өглөг, авлага шинээр үүсгээгүй бөгөөд өмнөх оны ажиллагсадтай холбоотой 2,447.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Харин өмнөх оны 9,913.6 мянган төгрөгийн өглөгийг холбогдох газарт хүсэлт тавьж шийдвэрлүүлэн барагдуулжээ.

**Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 541,474.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,010.5 мянган төгрөг, зардлыг 611,484.5

мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээнд 412.178.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70.010.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 514,350.0 мянган төгрөг буюу 91,96 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, хоол хүнсний зардал, тогтмол зардлууд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа материалын бусад зардлыг 583.4 мянган төгрөгөөс 26,595.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбө рга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71801	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>	<b>489,283.5</b>	<b>445,686.5</b>	<b>43,597.0</b>	<b>91.1</b>
80233	Хүүхэд хамгааллын зардал	574.2	574.2	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,168.9	876.7	290.2	75.17
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	36,134.2	34,581.1	1,553.1	95.7
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,940.0	1,940.0	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	878.7	100.0	778.7	11.3
81833	Явуулын багшийн үйлчилгээ	17,820.0	12,281.6	5,538.4	68.92
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	426,464.8	390,878.3	35,586.5	91.65
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	4,302.7	4,302.6	0	100
<b>Дүн</b>		<b>489,283.5</b>	<b>445,686.5</b>	<b>43,597.0</b>	<b>91.1</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
80109	Тогтмол зардал	70,010.5	68,663.5	1,347.0	98.1
<b>Нийт дүн</b>		<b>559,294.0</b>	<b>514,350.0</b>	<b>44,944.0</b>	<b>91.96</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 70,010.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 66,664.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,999.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1,347.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд хүнсний болон аж ахуйн материалуудад худалдан авалт зарласан байна.

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Ган доной ХХК-тай шууд гэрээ	Халаалтын зардал	60,635.5	60,635.5
2	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай шууд гэрээ	Хоол хүнс	36,114.2	34,581.0
<b>ДҮН</b>			<b>96,749.7</b>	<b>95,216.5</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 356,734.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 5,351.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,013.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Дөрвөлжин сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### **5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй**

#### **5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

#### **5.3 Зөвлөмж: өгөгдөөгүй**

Аудитын явцад материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-20

БОЛОВСРУУЛСАН:



Ц.ОЮУНСУВД  
Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР

Огноо: 2025-02-20

 Р.МЯДАГМАА